



БАТЛАВ
МОНГОЛЫН НЕВРОЛОГИЙН
НИЙГЭМЛЭГ ТЭРГҮҮН

Ж.САРАНГЭРЭЛ -2

МЭДРЭЛ СУДЛАЛ

АХЛАХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо /мэргэшлийн чиглэлийн сургалтад хамрагдаж, сүүлийн 3 жилийн турш 2-оос доошгүй багц цаг бүрдүүлсэн байх;
2. Сүүлийн 3 жилийн хугацаанд ажиллаж буй байгууллагын эмнэлгийн мэргэжилтэнд 3-аас доошгүй удаа мэдрэлийн эмгэгтэй холбоотой мэдээлэл өгсөн, илтгэл тавьсан, сургалт зохион байгуулсан байх, үүнийг байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байх;
3. Мэдрэл судлалын чиглэлээр 3 ба түүнээс дээш судалгааны бүтээл туурвисан байх, үүнийг мэргэжлийн сэтгүүл, дотоодын болон олон улсын хурлын илтгэлийн хураангуй номонд хэвлүүлсэн байдлаар баталгаажуулах;
4. Судалгааны 1 ба түүнээс дээшхи нь өгүүлэл хэлбэртэй, үүний 1-р зохиогч байх;
5. Судалгааны 1 ба түүнээс дээшхи нь өөрийн өдөр тутмын практик туршлагад тулгуурласан эмнэлзүйн судалгаа байх, эсхүл дотоодын буюу олон улсын хуралд ханан/аман илтгэлээр оролцсон байх;
6. Мэргэжлийн сэтгүүлд 1 ба түүнээс дээш эмнэлзүйн тохиолдол хэвлүүлсэн байх.

ТЭРГҮҮЛЭХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо / мэргэшлийн чиглэлийн сургалтад хамрагдаж, сүүлийн 3 жилийн турш 2-оос доошгүй багц цаг бүрдүүлсэн байх;
2. Сүүлийн 3 жилийн хугацаанд ажиллаж буй бүс, орон нутгийн эмнэлгийн мэргэжилтэнд 3-аас доошгүй удаа мэдрэлийн эмгэгтэй холбоотой мэдээлэл өгсөн, илтгэл тавьсан, сургалт зохион байгуулсан байх, үүнийг байгууллагын удирдлагаар баталгаажуулсан байх;
3. Сүүлийн 5 жилийн турш мэдрэл судлалын чиглэлээр 5 ба түүнээс дээш судалгааны бүтээл туурвисан байх, үүнийг мэргэжлийн сэтгүүл, дотоодын



- болон олон улсын хурлын илтгэлийн хураангуй номонд хэвлүүлсэн байдлаар баталгаажуулах;
- 2 ба түүнээс дээш судалгааны өгүүллийн 1-р зохиогч, эсхүл хариуцлагатай зохиогч байх;
 - 1 ба түүнээс дээшхи нь өөрийн өдөр тутмын практик туршлагад тулгуурласан байх, эсхүл олон улсын хуралд ханан/аман илтгэлтэй оролцсон байх;
 - Мэргэжлийн сэтгүүлд 3 ба түүнээс дээш эмнэлзүйн ховор тохиолдол хэвлүүлсэн байх;
 - Мэргэшлийн чиглэлээр багц цагийн сургалтад жил бүр 1 ба түүнээс дээш удаа илтгэл тавьсан байх, үүнийг хөтөлбөр, эсвэл илтгэлийн хураангуй номоор баталгаажуулах.

ЗӨВЛӨХ зэрэг горилогч эмнэлгийн мэргэжилтэн нь дараах тусгай шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулсан /мэргэжлийн нийгэмлэг, холбоо / мэргэшлийн чиглэлийн сургалтад хамрагдаж, сүүлийн 3 жилийн турш 2-оос доошгүй багц цаг бүрдүүлсэн байх;
2. Сүүлийн 3 жилийн хугацаанд мэдрэл судлалын салбар, үндэсний түвшинд болон бусад эмнэлгийн мэргэжилтэнд 3-аас доошгүй удаа мэдрэлийн эмгэгтэй холбоотой мэдээлэл өгсөн, илтгэл тавьсан, сургалт зохион байгуулсан байх;
3. Мэдрэл судлалын чиглэлээр сүүлийн 15 жилд 20 ба түүнээс дээш судалгааны бүтээл туурвисан, эсвэл ном, гарын авлага хэвлүүлсэн байх. /мэргэжлийн сэтгүүл, ном, дотоодын болон олон улсын хурлын илтгэлийн хураангуй, ном зэрэг хэвлүүлсэн байдлаар баталгаажуулах /;
4. Дээрх ≥ 20 судалгааны 5 ба түүнээс өгүүллийн 1-р зохиогч, эсхүл судалгааны хариуцлагатай зохиогч байх;
5. Дээрх ≥ 20 судалгааны 5 ба түүнээс дээш бүтээл нь өөрийн өдөр тутмын практик туршлагад тулгуурласан байх, эсвэл олон улсын хуралд ханан/аман илтгэлтэй оролцсон байх;
6. Мэргэжлийн сэтгүүлд 10 ба түүнээс дээш эмнэлзүйн ховор тохиолдол хэвлүүлсэн байх;
7. Сүүлийн 5 жилд багц цагийн сургалт зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд 5-аас доошгүй удаа ажилласан байх;
8. Мэргэшлийн хурал, чуулганд сүүлийн 5 жилийн турш 5-аас доошгүй удаа илтгэл тавьсан байх, үүнийг хөтөлбөр, илтгэлийн хураангуй номоор баталгаажуулах;
9. Орчин үеийн судалгаа, оношилгоо, эмчилгээний шинэ менежментийг таниулах сургалтыг байгууллагын хүрээнд тасралтгүй зохион байгуулж удирдах, мэргэшлийн чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа хийсэн байх. /Үүнийг зурагтай тайлангаар баталгаажуулах/;
10. Сүүлийн 5 жилийн хугацаанд дор хаяж нэг мэдрэлийн эмгэгийн заавар, стандарт боловсруулсан байх.